Монгол наадам цогцолбор ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/38 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монгол наадам цогцолбор ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,516,058.5 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага		19,940.0	19,940.0
Бараа материал	114,515.1	141,208.4	26,693.3
Урьдчилж төлсөн зардал	2,015.8	792.3	(1,223.4)
Үндсэн хөрөнгө	9,445,833.7	7,884,365.4	(1,561,468.4)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,562,364.6	8,046,306.1	(1,516,058.5)
Богино хугацаат өр төлбөр		20,003.4	20,003.4
Эзэмшигчдийн өмчийн дүн	9,562,364.6	8,026,302.7	(1,536,061.9)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,562,364.6	8,046,306.1	(1,516,058.5)

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэлд санхүүжилтын авлага 19,940.0 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 141,208.4 мянган төгрөг болж 26,693.3 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалтаар 278.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй 0.6 мянган төгрөг, нийт 279.4 мянган төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, зарцуулалтаар 205.3 мянган төгрөг, 47.5 мянган төгрөгийн барааг акталж, нийт 252.7 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,884,365.4 мянган төгрөг болж, 1,561,468.4 мянган төгрөгөөр буурсан нь Өмчийн харилцааны газрын 2025 оны 1/1805 дугаар албан бичгээр 3 нэрийн 18 ширхэг 77,873.3 мянган төгрөг, 2025 оны А/73 дугаар албан бичгээр 5 ширхэг 1,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө балансаас балансад шилжин ирж, 301,989.9 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авч, залруулгаар бараа материалаас 4.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлж, нийт 385,463.2 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/591 дугаар тушаалаар 11 нэр төрлийн 132,806.7 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгө, А/153 дугаар тушаалаар 5 нэр төрлийн 14,713.6 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгө, А/706 дугаар тушаалаар 77 нэр төрлийн 192,051.3 мянган төгрөгийн, нийт 339,571.6 мянган төгрөгийн хөрөнгө акталснаар хасагдаж, данснаас хасагдсан хөрөнгийн 330,492.7 мянган төгрөгийн элэгдэл болон тайлант үеийн элэгдлийн зардал 1,937,852.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Өр төлбөрийн үлдэгдэл 20,003.4 мянган төгрөг болж өссөн байна. Өр төлбөр дансанд нийгмийн даатгалын шимтгэлийн 37.4 мянган төгрөг, ХХОАТ-т төлөх 26.0 мянган төгрөг, харилцагч байгууллагад төлөх 19,940.0 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

3.5. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монгол наадам цогцолбор ОНӨААТҮГ-ын дарга нь

байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 25-ны 05-03/7417 дугаар тушаалаар тус байгууллагын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,817,555.2 мянган төгрөг, нийт зардлыг 1,817,555.2 мянган төгрөг байхаар баталсан байна.

Гүйцэтгэлээр өөрийн үйл ажиллагаанаас 381,776.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,341,121.4 мянган төгрөг, нийт 1,722,897.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,574,297.4 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажилласан байна. Зарцуулагдаагүй үлдэгдэл 148,600.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нийт урсгал зардлын 99.4 хувь буюу 1,564.7 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардал, 0.6 хувийг урсгал шилжүүлэгт зарцуулсан байна.

Бараа үйлчилгээний зардлын 69.1 хувийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, 9.2 хувь буюу 144,179.8 мянган төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 8.2 хувь буюу 129,537.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамжийн зардалд, 3.0 хувь буюу 47,369.1 мянган төгрөгийг хангамж, бараа материалын зардалд зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн жилийн явцад Нийслэлийн засаг даргын тамгын газраас 238,881.0 мянган төгрөг, үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооноос 126,923.2 мянган төгрөг, УБ хотын захирагчийн ажлын албанаас 304,996.0 мянган төгрөг, Аялал жуулчлалын газраас 13,375.0 мянган төгрөг, бусад байгууллагаас 33,106.0 мянган төгрөг, нийт 717,281.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс холбогдох үйл ажиллагааны зардалд 697,216.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 20,065.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ. Үүнээс 19,940.0 мянган төгрөгийг буцаан авахаар санхүүжилтын авлагаар бүртгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Монгол наадам цогцолбор ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн дотоод бүртгэлийг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Мэдээлэл аудит ХХК-ийн ахлах аудитор Ц.Отгонжаргал, аудитор Н.Ганданбаавар нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер А. Гэрэлмаа, гүйцэтгэх захирал Д. Товуудорж, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын албаны аудитын менежер Д.Отгонбаяр, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол наадам цогцолбор ОНӨААТҮГ-ын 2026 оны санхүүгийн тайланг Мэдээлэл-Аудит ХХК-д 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 2,392,184.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,921.8 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 4,051,307.0 мянган төгрөгөөс төгрөгөөс 1.0 хувиар тооцож 40,513.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тайлант оны нийт орлого өмнөх оноос 991,253.2 мянган төгрөг буюу 61.0 хувиар, нийт зардал 1,659,122.1 мянган төгрөг буюу 69.0 хувиар өссөн байгаа тул 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаар тооцооллоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь гадаад томилолтын зардал гаргаагүй, суурин утасны төлбөрөөс өөр төрлийн утасны зардал гаргаагүй, байр ашиглалтай холбоотой зардлаас 7,549.3 мянган төгрөг, цалингийн зардлаас 181,465.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлаас 4,748.9 мянган төгрөг, томилолт зочны зардлаас 0.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 40,343.3 мянган төгрөгийн зардлуудыг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 5 саяас дээш үнийн үнийн дүнтэй орлогын 1,321,295.4 мянган төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 165,230.4 мянган төгрөгийн 5 гүйлгээг хугацаа хоцроон байршуулсан, өмнөх аудитын 324/18625487НТАГ/049/НА-СТА-ОНӨҮГ дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгадагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, залруулах ажлыг зохион байгуулсан байна", 19.2-т "Шалгадагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг хуульд заасан тогтоосон хугацаанд бүрэн мэдээлээгүй, өмнөх аудитын албан шаардлага хэрэгжээгүй тул сахилгын хариулага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 110,123.5 мянган төгрөгийн 4 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 90,677.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, зөрчлийг арилгасан байна. Биелэлт хангалтгүй 1 алдаа, зөрчлийг аудитын илрүүлэлт хэсэгт тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1 зөвлөмж, 226,939.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгснийг үнэлэхэд зөвлөмж хэрэгжиж, албан шаардлага хэрэгжээгүй байна.

Хүснэгт 2. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Б	1	2	3	4	5	6
1	Зөвлөмж	1		1		100.0
2	Албан шаардлага	1	226,939.5			0.0
	Нийт дүн	1	226,939.5	1		100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/111 дүгээр тушаалаар нийт 9,557,428.5 мянган төгрөгийн үнэ бүхий хөгжмийн иж бүрдэл хөрөнгийг данс бүртгэлдээ авч, цаашид иргэн хуулийн этгээдэд түрээслүүлж, нийслэлийн төсвийн орлогыг бүрдүүлэхээр даалгажээ. Гэвч хөгжим дууны системд хийсэн дүгнэлтээр 40.7 хувь нь ажилладаггүй, цаашид сэлбэж ажиллуулахаар бол дээрх хөрөнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг шийдвэрлэх, хөгжмийн иж бүрдэл дутуу, уг хөрөнгийг 2016 онд үйлдвэрлэсэн, хөгжим, дууны тоног төхөөрөмжийг засварлан түрээслүүлж орлого бүрдүүлэх боломжгүй бөгөөд өмнө нь ашиглаж байсан байгууллага нь нягтлан бодох бүртгэлд тусгаагүйгээс элэгдэл тооцож байгаагүй байна. Тус хөрөнгийг дээрх тушаалын дагуу бүртгэх хүндрэлтэй байгаа тухай 2024 оны 12 дугаар сарын 31-ны 121 дүгээр албан бичгээр Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлснийг тус байгууллагаас комисс ирж нөхцөл байдалтай танилцсан боловч шийдэгдээгүй байгааг дараагийн аудитаар авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 8,900.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн шинжгүй, ашиглах жил тодорхойгүй цахилгааны кабель утас, чанга яригч цагаан хоолой зэрэг 8,900.0 мянган төгрөгийн бусад эргэлтийн бус хөрөнгийг үндсэн хөрөнгөөр бүртгэн авч ангилал буруу бүртгэснийг;

Эдгээр нь НБББОУС1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 15-д "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 24,076.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 19,446.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 4,630.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Нийт аудитаар илрүүлсэн 24,076.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1. Албан шаардлага

Илрүүлэлт: Нэг байгууллагаас бараа материал худалдан авахдаа тендер шалгаруулалтын журмыг хэрэглээгүй, төсөвт өртгийг 19,446.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн шууд гэрээ байгуулж, холбогдох хууль, журмыг мөрдөөгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", , 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 34 дүгээр зүйлийн 34.1-т "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно" заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолтой нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдэлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаанд өрсөлдөх тэгш боломж бүрдүүлээгүй, тендер шалгаруулалтын аргыг хэрэглээгүй худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2. Зөвлөмж

Илрүүлэлт: Техникийн комиссын дүгнэлтгүй 4,630.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн засвар хийсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 3.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Техникийн комиссын дүгнэлтэд үндэслэн тээврийн хэрэгслийн болон бусад техникийн засвар үйлчилгээг хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Үндсэн хөрөнгийн шинжгүй, ашиглах жил тодорхойгүй 8,900.0 мянган төгрөгийн барааг үндсэн хөрөнгөөр бүртгэн авч ангилал буруу бүртгэсэн	1	8,900.0			1	8,900.0						
	Дүн	1	8,900.0			1	8,900.0						

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бараа материал бэлтгэхдээ шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг 19,446.2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн.	1	19,446.2			1	19,446.2						
2	Техникийн комиссын дүгнэлтгүй 4,630.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн засвар хийсэн.	1	4,630.0					1	4,630.0				
	Дүн	2	24,076.2			1	19,446.2	1	4,630.0				

Монгол наадам цогцолбор ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцох албан шаардлага					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн данстай холбоотой зөрчил										
Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 5 саяас дээш үнийн үнийн дүнтэй орлогын 1,321,295.4 мянган төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 165,230.4 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроон байршуулсан	1	1,486,525.8					1	1,486,525.8		
			Нийт дүн							
	1	1,486,525.8					1	1,486,525.8		



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 203 / 13410508

Улаанбаатар хот

HN-2026/138/HA-CHA-CHAY

Сахилгын хариуцлага тооцуулах
түхай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол наадам цогцолбор ОНБААТУГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 1,321,295,363.42 /нэг тэрбум гурван зуун хорин нэгэн сая хоёр зуун ерэн таван мянга гурван зуун жаран гурван төгрөг дөчин хоёр мөнгө/ төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 165,230,398.50 /нэг зуун жаран таван сая хоёр зуун гучин мянган гурван зуун ерэн найман төгрөг тавин мөнгө/ төгрөгийн 5 гүйлгээг хугацаа хоцроон байршуулсан, өмнөх аудитын 324/18625487НТАГ-2025/049/НА-СТА-ОНӨҮГ дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, залруулах ажлыг зохион байгуулсан байна", 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г.корпус. 5 даахар

1. Зөрчил гаргасан ерөнхий нягтлан бодогч П.Гэрэлтуяад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Монгол наадам цогцолбор ОНӨААТҮГ-ын дарга /Д.Отгонбаатар/-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Д. ТОВУУДОРЖ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, В дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 даахар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 304 / 18 110508

Улаанбаатар хот

НТМ-2026/138/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол наадам цогцолбор ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэг байгууллагаас бараа материал худалдан авахдаа тендер шалгаруулалтын журмыг хэрэглээгүй, төсөвт өртгийг 19,446,200.00 /арван есөн мянга дөрвөн зуун дөчин зургаан мянга хоёр зуу/ төгрөгөөр хэтрүүлэн шууд гэрээ байгуулж, холбогдох хууль, журмыг мөрдөөгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, харьцуулагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно" заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолтой нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэг биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан өргөжүүлэхгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагаанд өрсөлдөх тэгш боломж бүрдүүлээгүй, тендер шалгаруулалтын аргыг хэрэглээгүй худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090555

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол наадам цогцолбор ОНӨААТҮГ-ын дарга /Д.Отгонбаатар/, нягтлан бодогч /П.Гэрэлтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК ЗАХИРАГ

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Д.ТОВУУДОРЖ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар